

**Монгол бичигийг боловсронгуй болгох гэсэн оролдолго,  
түүний мөн чанар хийгээд үр дүн нь ...**

**Ц. Шагдарсүрэн\***

Монгол бичигийн дурасхалыг он дараалан үзвэл монгол бичигийг “*боловсронгуй болгох*” гэсэн оролдолго хэдэнтээ гарчээ. Үүнийг монгол бичигийн үсэгзүй болон зөв бичихзүйг “*боловсронгуй болгох*” гэсэн, мөн үүний хажуугаар бичигийн өөр тогтолцоогоор солих гэсэн оролдолго гэж хоёр хувааж болно.

Монгол бичигийг өөр бичигийн тогтолцоогоор солих гэсэн оролдолго хэдэнтээ гарсан, түүний мөн чанар юу болох, зорилго үр дүн хоёр нь нийцсэн эсэх тухай үүнээс өмнө хэдэнтээ хөндөн өгүүлсэн<sup>1</sup> тул дахин нурших хэрэггүй гэж үзээд энэ удаа монгол бичигийн дотоод дахи үсэгзүй болон зөв бичихзүйд хийсэн өөрчлөлтийн мөн чанар хийгээд тэдгээрийн ил далд үр дүнгийн талаар эл өгүүлэлдээ тодруулахыг хичээв.

**1. Үсэгзүй (ҮЗ)-н хүрээнд:**

**1. 1. Монгол бичигт *a, e* хоёрыг ялгасан нь:** Монгол бичигээрхи түрүү үеийн тухайлбал: Ил хаадын захидал болон Түрфанаас олдсон бичвэрт, одоо бидэний “тусхай” *e*- үсэгээр буюу ганц ацагаар эхлэн бичдэг *элэнцэг* (< elinceg), *өвөг* (< ebuge), *эцэг* (< esige) [1-р зураг], *эрт* (< erte) [2-р зураг] гэх зэрэг олон үгийг хоёр ацагтай буюу одоогийн бидний мэдэж буй

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол Судлалын Төв

<sup>1</sup> Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Үсэгзүйн судлагаа, (Хүннүгийн үеэс өдгөө хүртэл Монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичигийн судлагаа), Улаанбаатар, 2001, 277-279-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын бичиг үсэг*, - *Монголын судлалын эрдэм шинжилгээний бичиг* (МУИС, Монгол хэл соёлын сургууль), 17 (169)-р боть, Улаанбаатар, 2001 он, 28-75-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 2003, 91-94-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн уламжлалыг судлахад...* - Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулж МУИС-иас зохион байгуулсан “Их Монгол Улс, Эзэнт гүрэний түүх соёлын асуудал” Олон улсын ЭШ-ний хурал (МУИС, 2006. 6. 23-24, Улаанбаатар)-д тавьж хэлэлцүүлсэн илтгэл; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн уламжлалыг судлахад...*, - Их Монгол Улс, Эзэнт гүрний түүх, соёлын асуудлууд, Улаанбаатар, 2006, 145-147-р тал.

*a-* тай адил бичсэн байдаг билээ. Хэлшинжлэлд онцгой бичилгэ хоёроос дээш тохиолдвол тогтолцоо гэж үзэх учиртай тул дээрхи олон баримтыг тохиолдол гэж хэлэх аргагүй. Энэхүү бичилгийг түүхэн авиазүйн үүднээс монгол бичигийн *титэм* ямар үүрэгтэй байсан бэ? гэдэг талаас нь профессор Ж. Лувсандорж ажин судлаад сонирхолтой өгүүлэл бичсэн нь буй<sup>2</sup>.

Энэхүү өвөрмиц бичилгийг үсэгзүйн үүднээс авч үзэх бөгөөс монгол бичигийг анх зохиох үед монгол хэл эр эмээр ялгарсан найман эгшигтэй байсаны ул мөр харагдаад зогсохгүй, монгол хэлний нутаг нутагийн аялгуунд сэлгэдэг байдалыг нь давхар харгалзаж тэдгээр найман эгшигийг эр эмээр нь дөрвөн үсэгээр

ᠠ (a~e), ᠠ (i~i), ᠡ (o~u), ᠢ (ö~ü)

хэмээн тэмдэглэж ирсэн нарийн тогтолцооны гэрч гэж үзэх бүрэн боломжтой юм<sup>3</sup>. Өөрөөр хэлбэл одоо бидэний *a-*, *e-* гэж хоёр дүрсээр бичиж буй хоёр үсэг нь анх ганц хэлбэртэй буюу *a-* хэлбэртэй байсаны баримт гэсэн үг. Ингэж тэмдэглэж байсан нь, одоогийн зарим хүний үздэгчилэн монгол бичиг боловсронгуй бусын учир нэг үсэгээр хэд хэдэн авиаг тэмдэглэж ирсэн хэрэг огт бус, монгол хэлний олон аялгуутан тухайлбал: *соёл* гэдэг үгийг төв халхад *сойол*, өвөрхангайн зарим аялгуунд *суйул*, *өндөр* гэдэг үгийг төв халхад *өндэр*, буриадад *үндэр* гэдэг шиг, зарим аялгуутан *нийслэл*, *чийрэг* гэж байхад нөгөө нэг нь *найслал*, *чийраг* гэж хэлдэг, аялгуу аялгуутанд тодорхой эгшиг авиа сэлгэдэг байдалыг нэг авиалбар (phoneme)-ын хувилбар хэмээн зөв таниж, монгол бичигт эгшиг үсэг тэмдэглэхдээ нарийвчилан тусхасан явдал болохоос биш үсэг нь цөөдөөд нэг үсэгээр хоёр авиаг тэмдэглэсэн хэрэг бүр биш байх нь. Цаашлуулан бодвол, ингэж тэмдэглэсэнээр монгол хэлийг бүрдүүлж өгдөг нутаг нутагийн аялгууг, аль нэгэн зонхилох нөлөөтэй аялгуунд уусгалгүй, өөр өөрийнхөө замаар бие даан хөгжих бололцоогий нь ханган өгчээ.

Ингэж тэмдэглэж ирсэн нь орчин цагийн хэлшинжлэлийн үүднээс “хэл” гэдэг бариад авах бодтой зүйл биш, харин “хэлэхүй”-гээр илэрдэг хэмжигдэхүүн болохыг сайтар ухаарсаны нутлагаа. Хэлэхүй нь нутаг нутагийн аялгуутанд тэгш хүртээлтэй, тэгээд ч халх, буриад, ойрод... аялгуутаныг нийтэд нь монгол хэлтэн гэдэг биз дээ. Иймэд нутагийн аялгууг аль нэгэн зонхилох аялгуунд уусгах эрмэлзэл нь гаднаасаа нэгэдмэл байдал руу тэмүүлэх мэт харагдаж болох ч, бие цогц эрхтэний аль нэгий нь үгүй хийсэнтэй адил, тухайн хэлний орших насыг яв ч уртасгахгүй нь тодорхой юм.

Хэдий ийм боловч унших, бичих, сурахад амар хялбар болгох гэсэн эрмэлзэлээс үүдэн, монгол бичигийн дотоодод зөвхөн энэ тохиолдолд *a-*, *e-* хоёрыг [ᠠ (a), ᠡ (e) гэж] ялган тэмдэглэх болсон, түүнчилэн тод, вагиндра ... бичигт бүх эгшигийг ялган тэмдэглэх зорилгыг гол болгосон зэрэг нь тухайн нэг зонхилох аялгуутанд амар хялбар болох талтай ч, монгол

<sup>2</sup> Ж. Лувсандорж, *Эртний монгол бичигт үгийн эхний Алеф үсгээр ямар авиа тэмдэглэсэн бэ?* – Эрдэм шинжилгээний бичиг (Монгол Улсын Их сургууль), Улаанбаатар, 1987, 35-44-р тал.

<sup>3</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 6 (1998), Seoul, 1999, [pp. 61-139] 51-р тал; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм* (нэмэн зассан хоёдугаар хэвлэл), - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл, II дэвтэр), Улаанбаатар, 1999, [67-125-р тал] 103-р тал.

бичигийн нарийн ширийн учир холбогдолыг гүйцэд ухаараагүй тул нийт монгол хэлтэний тухайд аялгуу аялгуутаныг бичигээр нь салгах үйл явцад санамсаргүй хүргэсэн гэж хэлэх үндэстэй юм.

Монгол бичигийг анх тэргүүнээ боловсруулах үед *a*, *e* хоёр эгшигийг тийнхүү нэгэн хэлбэртэй буюу хоёр ацагтай бичиж байсан нь монгол бичигийн үсэгзүйн тусхай шийдэл байжээ. Ийнхүү үгийн эхинд тохиолдох бүх эгшигийн өмнө “*түтэм*” тависан нь авиазүйн үүднээс тухайн эгшигийн өмнө үлдсэн ямар нэгэн гийгүүлэгчийн ул мөр буюу амисхалын түрэлтийг тэмдэглэсэн хэрэг байх бүрэн үндэстэй бөгөөд энэ нь өвөг монгол хэлний үед эгшигээр эхлэсэн үг байсан эсэх асуудалтай давхар холбоотой юм. Үүний дээр, өдгөөгийн монгол хэлний олонхи аялгуунаа нэгэнт үгүй болсон боловч монгол дөрвөлжин, хятад, араб бичигээр тэмдэглэгдэж ирсэн дундад үеийн монгол хэл (Middle Mongolian = ММ)-ний дурасхал дахи шүргэх *h*-гээр эхлэсэн олон үгийн учир начирыг тайлах сэжүүрийг бидэнд бариулж өглөө гэж үзэх үндэс буй. Бас тэрхүү шүргэх *h* авиа нь одоо дагууруудын хэлнээ хэлний арын шүргэх “*х*”-гээр үлдсэний<sup>4</sup> учир холбогдолыг ч тайлах баримт болж өгнө. Жишээ нь:

Халх монг: <i>арбан</i>	ММ: <i>harban</i>	Даг: <i>харбан</i>	< Мо: (* <sup>4</sup> ) <i>arban</i> ;
Халх монг: <i>улаан</i>	ММ: <i>hula'an</i>	Даг: <i>хулаа(н)</i>	< Мо: (* <sup>4</sup> ) <i>ulayan</i> ;
Халх монг: <i>язгуур</i>	ММ: <i>huja'ur</i>	Даг: <i>хожоор</i>	< Мо: (* <sup>4</sup> ) <i>ijayur</i> ;
Халх монг: <i>үүр</i>	ММ: <i>e'u:r<sup>5</sup></i>	Даг: <i>хээр</i>	< Мо: (* <sup>4</sup> ) <i>egür</i> ;
Халх монг: <i>он</i>	ММ: <i>hon</i>	Даг: <i>хон</i>	< Мо: (* <sup>4</sup> ) <i>on</i> .

Нэгэн зүйлийг нэмэн тэмдэглэхэд, монгол хэлний дээрхи үзэгдэлтэй яг адилхан баримт орчин цагийн түрэгийн олон хэлэнд байдаг. Жишээ нь: *Амьтан* (animal) гэдэг үг түрэгийн олон хэлнээ дараахи байдалтай байгааг 1996 онд гарсан “*Түрэг хэлнүүдийн толь*”-д дараахи байдалаар харуулжээ<sup>6</sup>.

ANIMAL:	Azer., >	heyvan
	Kazakh >	aywan
	Kirgiz >	ayban
	Tatar >	khayvan
	Turkish >	hayvan
	Turkmen >	haywan
	Uighur >	hayvan
	Uzbek >	hayvon

<sup>4</sup> Л. Б. Бадмаева, *Современные монгольские языки Северо-восточного ареала Центральной Азии*, - История и внешние связи Бурятского языка, Улан-Удэ, 2004, стр. [7-12] 8-10; В. И. Рассадин, *Особенности дагурского языка в сопоставлении с бурятским и монгольским языками*, - История и внешние связи Бурятского языка, Улан-Удэ, 2004, стр. [13-17] 14.

<sup>5</sup> Н. Н. Поппе, *Монгольский словарь Мукаддимат Ал-адаб*, I-II, Москва-Ленинград, 1938, стр. 168.6; *The Mongolian Words in the Muqaddimat al-Adab: Romanized Text and Word Index* (as of January 2008), Tokyo, 2008, p. Text-413.

<sup>6</sup> Kurtuluş Öztopçu, Zoumagaly Abuov – Nasir Kambarov, Youssef Azemoun, *Dictionary of the Turkic Languages* (English: Azerbaijani, Kazakh, Kyrgyz, Tatar, Turkish, Turkmen, Uighur, Uzbek), London & New York, 1996, [361 pp.], p. 7.b.

Энэ жишээнээс үзэхүл зарим хэлэнд хэлний арын “х” гийгүүлэгч нь байхад зарим хэлэнд нь нэгэнт үгүй болжээ. Харин тодруулан хэлэхэд уг тольд латин галигаар тухайн үгийг тэмдэглэхдээ зарим тохиолдолд “h” үсэг хэрэглэсэн нь дундад үеийн монгол хэлнээ үгийн эхинд байсан, одоо буриадын аялгуунаа байдаг шүргэх h-тэй адилгүй, англи хэлний жишигээр тэмдэглэсэн гэж ойлговол зохино. Хэдий тийм боловч энэ бүх баримт нь монгол болон түрэг зүгийн хэлнүүд угтаа гарал нэг байсаныг ямар нэгэн хэмжээгээр харуулж байгаа баримт гэж үзүүштэй санагдана.

Энэ бүхэнээс үзэхэд монгол бичигийн үсэгзүйд үгийн эхинд тохиолдох бүх эгшигийн өмнө цөмд нь “титэм” тависан нь тухайн үеийнхээ монгол хэлний нутаг нутагийн олон аялгууны онцлогийг бүрэн тусхаж тэрхүү титэмийг өөр өөрийнхөө аялгууны онцлогоор байх ёстой эгшиг, гийгүүлэгч буюу байхгүй болсон байдалаар, өөрөөр хэлбэл монгол бичигт нэг үсгээр тэмдэглэдэг бүх авиаг нутаг нутагийнхаа дуудалгад зохицуулан өөр өөрийнхөөрөө унших боломжийг хангах тусхай зарчимд хамааруулсан байдал бэлхэнээ харагдана.

**1. 2. Монгол бичигт j, y хоёрыг ялгасан нь:** Монгол бичигийн түрүү үеийн дурасхалыг үзвэл XVIII зууныг хүртэл гийгүүлэгчийн үүргээр орж буй шилбэ (ᠵ гэсэн) нэгэн хэлбэртэй тохиолддог байсан бөгөөд нутаг нутагийн аялгуунд тухайн авиа сэлгэдэгээс үүдэж (j~y гэсэн) хоёр дуудалгатай байсан билээ. Тэгээд ч одоо зам гэх болсон, угтаа *jam* байсан үгийг олон нутагийнхин

> Халх монг.: *dzam*

> Өвөр монг.: *džam*

Мо. ᠵᠠᠮ jam ‘зам’; унших боломж олон: >

> Буриад монг.: *zam*

> Ойрод монг.: *yam*

гэх мэтээр зарим нь *жам*, зарим нь *зам*, зарим нь *ям*, бүр нарийсгавал: хамжин шүргэх *dz*, *dž* юм уу, шүргэх *z* гийгүүлэгчээр өөр өөрийнхөө аман аялгуугаар ялган дуудсаар ирсэн боловч монгол хэлнийхээ нэгэдмэл утгаар “ялгаагүй” ойлгосоор иржээ. Энэ бол орчин цагийн монгол хэл аялгууны онцлогтой холбоотой.

Монгол бичигийн үсэгзүйн энэ онцлог нь монгол хэлний хөгжилийн түүхэнд ч бас холбогдоно. Тухайлбал: хятан хэлний баримтаас үзэхүл орчин цагийн монгол хэлний *найр*, буюу монгол бичигийн хэлний Мо. *найр* гэдэг үг хятанд *najir* байсан байх бөгөөд үүнийг одоогийн дагуур аялгуутан ч тэр хэвээр нь хэрэглэсээр бөлгөө.

> Хятан: *najir*

Мо. ᠨᠠᠶᠢᠷ *najir* ‘найр’; унших боломж нь: >

> Төв монгол: *najir*

> Дагуур: *najir*.

Энэ мэтээр *j*-у гийгүүлэгч сэлгэх нь зөвхөн нутаг нутагийн аялгуунд төдийгүй нэгэн аялгууны дотор ч байдаг байна. Тухайлбал: халхын аялгуунаа өвдөхөд хэлдэг “*eo eo*” гэдэг аялга үг балчир хүүхэдийн үгийн санд “*жо жо*”, “*жо жо болох*” гэдэг хэлбэртэй байгааг тайлбарлаж гэмээ нь дээрхи үзэгдэлтэй холбож үзэхээс өөр аргагүй. Ер нь *j*-у гийгүүлэгч сэлгэх нь бусад олон хэлнээ байдаг авиазүйн нийтлэг үзэгдэл бөгөөд европ зүгийн олон хэлнээ латин *j* үсгийг өөр өөрийнхөөрөө буюу *j*-у-ээр дууддагийг хялбарханаа харж болно.

Ийн атал, амар хялбар болгох гэсэн мөнөөхи “гэнэн” эрмэлзэлийн үүднээс XVIII зууны сүүл үеэс хэлний хажуугийн у гийгүүлэгчийг (◃)-ээс ялгаж (◃ - у хэмээн) тэмдэглэх болсон нь өнгөнөөс нь харахад ялгахуйяа амар мэт болсон боловч нийт монгол хэлтэнийг нутаг нутагийнхаа аялгуугаар салан холдох, бас (◃) байх бөгөөс хуучин шигээ буюу өөр өөрийнхөө хэлдэгээр (*j*-у) гэж хоёр янзаар уншиж болохгүй, зөвхөн (*j*) гэж унш!, (◃) байх бөгөөс ганцхан (*y*)-гээр унш! гэх мэтээр тулган хүлээлгэж, өөрийнхөөрөө унших олон боломжийг хязгаарласанаараа бусад аялгуутаныг зонхилох (төв) аялгуутаны хэлний онцлогт баригдаж уугуул аялгуугаа гээхэд арга буюу хүргэсэн ажээ.

Бас нэгэн зүйл: Монгол бичигт *j*, *y* хоёр гийгүүлэгчийг ганц (◃) хэлбэрээр тэмдэглэсэн нь зөвхөн монгол хэлний хувьд гэлтгүй Алтай хэлний түүхэн судлалд ч хамааралтай ажээ. Тухайлбал: монгол хэлний “*заан*” (< Мо. *jaγan*) гэдэг үгтэй тохирох хэлбэр бүхий *yaγan* ~ *yaγan* гэдэг үг эртний түрэг хэлнээ байдаг бөлгөө. Энэ үгийг оросын түрэгч эрдэмтэн А. М. Щербак монгол хэлний “*заан*”-тай холбон үзэхдээ хятад гаралтай байж болохыг дурадсан нь буй<sup>7</sup>. Уг саналыг оросын нангиадач эрдэмтэн С. Е. Яхонтов дэмжиж хятад хэлний “*xiàng*” буюу “*заан*” гэдэг үгтэй холбон, уг хятад үгийн эхиний “*x*” буюу [*ʃ*] гийгүүлэгч нь VIII зуунаас өмнө дуутай “*z*” байсан бөгөөд тэр үед монгол хэлнээ орж, монгол [бичигийн] зөв бичих зүйгээр эгшигийн уртыг тэмдэглэх аргаар “*y*”-г нэмэн “*jaγan*” хэмээн тэмдэглэх болсон буй заа, түүнээс бус уг нангиад хэлнээ “*y*” гийгүүлэгч ерөөсөө байхгүй хэмээн тайлбарлажээ<sup>8</sup>. Энэхүү тайлбар нь эртний түрэг хэлний *yaγan* ~ *yaγan* (< Мо. *jaγan*) гэдэг үгийг монголоос авсан болохыг батлаж байгаа боловч уг үг нангиад гаралтай гэдэгт батлагаа болох эсэх нь эргэлзээ төрүүлнэ.

Харин монгол бичигийн Мо. *jaγan* гэдэг бичилгэ нь нэг талаас, хэрэвзээ VIII зуунаас өмнөхи үеийн хятад дуудалгатай холбоотой гэж үзэх бөгөөс монгол бичигийн гаралын цаг үеийг тэр үед хамааруулах боломжтой болж өгнө, нөгөө талаас, монгол хэлнээ орсон бусад хятад үгийн монгол бичилгэтэй харьцуулахад<sup>9</sup> илэрхий өвөрмиц тул яг нангиад гаралтай үг мөн эсэхэд эргэлзээ төрүүлнэ. Одоо монголд хэдийгээр заан гэдэг амьтан байхгүй боловч монгол нутаг дахи хадны сүг зурагийн санд тэмээ, буга, шувуу тэргүүтэнээс гадна (наад зах нь: Хойд Цэнхэрийн агуйн хананаа улаан зосоор зурсан) заан, арслан заан, тэмээн хяруул

<sup>7</sup> А. М. Щербак, *Ранние тюркско-монгольские языковые связи* (VIII-XIV), Санкт-Петербург, 1997, стр. 121.

<sup>8</sup> С. Е. Яхонтов, *Некоторые алтайские этимологии* – Материалы конференции посвященной 100 летию со дня рождения профессора В. И. Цинциус (13-14 октября 2003), Санкт-Петербург, 2003, стр. 263-269.

<sup>9</sup> D. Kara, *On Sino-Mongol Cultural Relations as Seen in the Mongolian Lexicon*, - Menggu minzu yu zhoubian minzu guanxi, Taipei, 1999, pp. 61-80.

зэрэг өдгөөгийн монгол нутагт байхгүй амьтадын дүрс байдагийг<sup>10</sup> эргэн санаж, холбон бодолцоход яав ч илүүц зүйл болохгүй.

Энэ мэтээр түрэг хэлнүүдэд *j*, *y* гийгүүлэгч сэлгэдэг олон баримтыг нэмэн хэлж болно. Тухайлбал: “Түрэг хэлнүүдийн толь” бичигээс “ганц, ганцаараа” (along) гэдэг үгийг жишээ болговол<sup>11</sup>:

ALONE:	Azer., >	yalgiz
	Kazakh >	zhalghiz
	Kirgiz >	jalgiz
	Tatar >	yalgiz
	Turkish >	yalniz
	Turkmen >	yeke
	Uighur >	yalghiz
	Uzbek >	yolg'iz

гэх мэтээр *j*, *y* гийгүүлэгч сэлгэсэн баримт олон буй.

**1. 3. Монгол бичигт *n*, *y*-д цэг нэмсэн нь:** Монгол бичигийн дурасхалыг “Чингисийн чулууны бичиг”-ээс эхлэн, модон барын ном, “Цогтын чулууны бичиг” ... зэргээс үзвэл XVIII зууны сүүл үе хүртэл цөмд нь (*n*, *y*-д:  $\rightarrow$   $\leftarrow$   $\rightarrow$  /  $\rightarrow$   $\rightarrow$   $\rightarrow$  гэх мэтээр) цэг тавьдаггүй байжээ [3-р зураг: Цогтын хадны их бичээсийг үзнэ үү]. Сайтар нягтлан аживаас энэ нь нийт монгол хэлтэнийг хэлний нь хувьд нэгэдхэх, нутаг нутагийн аялгууг өөр өөрийнхи нь замаар эрх тэгш хөгжүүлэх гэсэн монгол бичигийн дээр дурадсан гол зорилготой холбоотой байсан гэж үзэх бүрэн үндэс буй.

**1. 3. 1.** Одоо халхын аялгуунд эгшигээр эхлэсэн *илч* (Mo. *ilci*), *ялгал* (Mo. *ilyal*) гэх зэрэг нэг бус үг ойродын аялгуунд *n*- гийгүүлэгчээр эхлэж, *nilci*<sup>12</sup>, *nilyanli*<sup>13</sup> гэдэг хэлбэрээр байгааг бичигийн дурасхалаас олсоныгоо эрдэмтэд ажин тэмдэглэжээ. Үүний *nilci* гэдэг үгийн утга хийгээд эрт өдгөөгийн хэрэглээний талаар нэмж хэлэх бас бус зүйл бий. Г. Ж. Рамстедт (G. J. Ramstedt)-ийн “Халимаг толь” болон тод “Субашид”-д гарч байгаа энэ үгийг Ж. Р. Крюгер (John R. Krueger) авгай англи орчуулгатай тольдоо ‘flame, heat’ хэмээн англичилжээ. Уг үг Захчины нэгэн хийдийн түүхийн гарчигт “...алтан нараны гэрэлийн **нилчи** тогтоон өгүүлэгсэн...Алтан эрихэн...” гэж тохиолддоогоос гадна одоогийн Халимаг нарын хэлэнд

<sup>10</sup> А. П. Окладников, *Центрально-Азиатский очаг первобытного искусства* (Пещерное росписи Хойт-Цэнхэр агуй, Западная Монголия), Новосибирск, 1972, стр. 122, Сүг зурагийн IV-V бөлөгт хамаарах өнгөт хавсралт...; Э. А. Новгородова, *Древняя Монголия*, Москва, 1989, стр. 45.

<sup>11</sup> Kurtuluş Öztopçu, Zoumagaly Abuov – Nasir Kambarov, Youssef Azemoun, *Dictionary of the Turkic Languages* (English: Azerbaijani, Kazakhn Kyrgyz, Tatar, Turkish, Turkmen, Uighur, Uzbek), London & New York, 1996, [361 pp.], p. 6.a,

<sup>12</sup> John R. Krueger, *Materials for an Oirat-Mongolian to English Citation Dictionary*, Parts: one – three, Bloomington, 1978-1984, p. 218 a; Gustav J. Ramstedt, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki, 1935, p. 276. b, 5; Kh. Luvsanbalдан, *Le Subhāṣitaranidhi oirat du Zaya Pandita*, -Acta Orientalia Hung. Tom. 26 (2-3), Budapest, 1972, pp. 195-225, see. 36 & 161;

<sup>13</sup> John R. Krueger, *Materials for an Oirat-Mongolian to English Citation Dictionary*, Parts: one – three, Bloomington, 1978-1984, p. 218 b; А. М. Позднеев, *Калмыцко-русский словарь...*, St.-Peterburg, 1911, стр. 224-a, 1.

нөлөө, нэр нөлөө, нэр хүнд гэсэн шилжимэл утгаар байсаар байгаа бөлгөө<sup>14</sup>.

Энэ мэт нутагийн аялгууны ялгаанаас гадна ер энгийн нийтлэг үг дээрээс ч холбогдох баримтыг олж болно. Жишээлбэл: “Монголын нууц товчоон”-д “...ebesun-ü alurqai-bar ...” гэсэн хэлэлгэ гурвантаа гарч байгааг андуу эндүү гэж үзэх аргагүй<sup>15</sup>. Энэхүү *alurqai* гэдэг үг нь утгазүй-хэлбэрсудлалын үүднээс, монгол хэлний *nalurqai* гэдэг үгтэй холбоотой нь маргаангүй бөгөөд монгол бичигийн түрүү үеийн бичвэрт амьтай ( $n+V$ ) болон дэвисхэр ( $-n$ )-ийн аль алины нь өмнө цэг тавьдаггүй байсанаас үүдэж буруу уншсан хэрэг бөгөөд энэ нь цаанаа тухайн уншигчийн хэл, бичигийнхи нь боловсролтой холбоотой гэж үзэх үндэс буй. Тийм ч учираас доктор Б. Сумъяабаатар “Монголын нууц товчооны толь” бүтээлдээ тухайн үгийн ард нь хаалтанд “налархай” хэмээн тодруулжээ<sup>16</sup>. Энэхүү “алдаа” нь “Монголын нууц товчоон”-ы анхны эх монгол бичигээр байсан, тэр үед эгшигээр амь авсан  $n$  -ийн өмнө одоогийнхи шиг цэг тавьдаггүй байсаныг давхар гэрчилэж байгаа хэрэг.

Гадаад үгийн тухайд ч энэ үзэгдэл хамаатай ажээ. Тухайлбал: *новаар* гээд байдаг нэгэн зүйл халуун үрийг *алишим* хэмээн хэлж, бичдэг баримт байдаг<sup>17</sup> нь угтаа *налишим* гэдэг үгээс гаралтай, тэгээд ч “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д уг үгийн тайлбарын эцэст “налишам” (? налишим!) гэж нэмэн оруулжээ<sup>18</sup>.

Дээрхи хэдэн жишээнээс харахад, нэг талаас тэдгээр үгийн хэрэглээ нь хязгаарлагдмал байх тул тэрхүү буруу уншсан жишиг тэр хэвээрээ тархахад нөлөөлсөн, нөгөө талаас бичигийн хүмүүсийн хувьд монгол хэлний унаган мэдрэмжтэй, монгол бичигийн хөгжил хувьсал, мөн нутаг нутагийн аялгууны онцлог ялгаа хийгээд гадаад нэр томъёоны үүсэл гаралын талаархи зохих мэдэлгэтэй байхыг анхааруулж байгаа юм.

1. 3. 2. Монгол бичигийн түрүү үеийн дурасхалд  $\Gamma$   $\gamma$  гийгүүлэгчийн өмнө яагаад цэг тавьдаггүй байсаны учир холбогдолыг олон жишээнд сатааралгүй халхын аялгуунд *халзан* гэдэг үгийг, даригангын аялгуунд *галзан* гэдэг тухай ганц үгээр товч тайлбарлаж болно. Түүхэн үүднээс авч үзвэл, наад зах нь дундад үеийн монгол хэлний өрнөд болон дорнод аялгууны баримт болсон монгол үгийг арабаар тэмдэглэсэн Истамбул, Лейдений толь болон монгол үгийг хятад үсэгээр тэмдэглэсэн Монгол Хуа-и и-юй толь бичигт *yaqai* > *qaqai*, *amiyulang* > *amiqulang*, *qayarqai* > *qaqarqai* гэх зэргээр  $q > \gamma$ ,  $\gamma > q$ -гийн сэлгэцийг олон баримтаар тэмдэглэжээ<sup>19</sup>. Бас зарим гар бичмэлд бидний хоёр цэг талбилгүй,  $q$  гэж үздэг

<sup>14</sup> *The History of a Jakhachin Buddhist Monastery Dharmabhadra's "Golden Rosary"*, facsimile edited and introduced by G. Kara and J. Tsooloo [Series Debter... N. 12], Budapest, 1997, p. 1; *Калмыцко-русский словарь, хальмг-орс толь*, под редакцией Б. Д. Муниева, Москва, 1977, стр. 378. б.

<sup>15</sup> Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, - Uralic and Altaic Series (Indiana University), Vol. 121, Bloomington, 1972, [347 pp], pp. 34, 39 [L: 1933, 20108 2320], 182; Б. Сумъяабаатар, Б. Нарангэрэл, *Монголын нууц товчооны толь*, Улаанбаатар, 2008, [875 тал], 34, 446-р тал.

<sup>16</sup> Сумъяабаатар, Б. Нарангэрэл, *Монголын нууц товчооны толь*, Улаанбаатар, 2008, [875 тал], 34, 446-р тал.

<sup>17</sup> Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 33а.

<sup>18</sup> *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*, I – V боть, Улаанбаатар, 2008 он, 75-р тал.

<sup>19</sup> L. Ligeti, *Un vocabulaire mongol d'Istanbul*, - Acta Mongolica Hung., Tom. XIV, Fasc. 1, Budapest, 1962, [pp. 3-99] See. pp. 40-47; L. Ligeti, *Notes sur le vocabulaire mongol d'Istanbul*, - Acta Mongolica Hung., Tom. XVI, Fasc. 2, Budapest, 1963, [pp. 107-174]; *Word- and Suffix-Index to Hua-yi Yi-yü*, Compiled by Hitoshi Kuribayashi, Tohoku University, Sendai, 2003, [178 pp.], See. pp. 120, 152.

тохиолдолд хоёр цэг тавьсан байдагийг бид нэгэнт зуршичихсан ойлголтоороо тэр нутагт  $\gamma$ -ийн өмнө биш,  $q$ -ийн өмнө хоёр цэгийг солин тавьдаг гэж үздэг маань хэр үнэмшилтэй вэ? гэдэг эргэлзээг төрүүлэхэд хүрнэ. Магадгүй тэр нь зуршисан ойлголт маань буруу болж, тухайн тэр аялгуунд хоёр цэгийг бидний бодсончилон сольж тавьсан хэрэг огт биш, бидний  $q$  гэж үздэг авиаг тухайн нутагт  $\gamma$ -аар дууддагийг тэмдэглэсэн байж ч бүрэн болно. Үүнийг тодруулбал зохино.

Энэ бүхэнээс яргуулан бодвол, нутаг нутагийн аялгуунд тухайн тохиолдолд  $Q q$ ,  $\Gamma \gamma$  хоёр гийгүүлэгч нэгэн авиалбарын хувилбар болдог тул монгол бичигийн хөгжилийн эхин үед монгол бичигт нэгэн адил дүрсээр тэмдэглэж, цэг тэмдэгээр тусхайлан ялгах шаардалгагүй хэмээн үзэж байсантай холбоотой байсан буй заа гэдэг үнэмшилтэй нь аргагүй магадлал гарч байна. Сүүлд  $Q q$ -аас ялгаж  $\Gamma \gamma$ -д хоёр цэг нэмсэн нь өөр өөрийнхөө аялгуугаар хоёр боломжоор уншиж байсан нэгэн үсэгийн тэмдэгтийг хоёр ялгасан нь чухамдаа ганц боломжоор, тэгэхдээ бусад аялгуутанд, тухайлбал эл тохиолдолд зонхилох гол (одоо бол халхын) аялгууг дагахаас өөр замгүй болгосон гэсэн үг. Профессор Ш. Чоймаа “Монголын нууц товчоон”-ыг Лувсанданзаны “Алтан товч”-той харьцуулсан эхийн судлагаандаа үүнд холбогдох цуваа цагийн сонирхолтой баримтыг нэхэн олж XVII зуун гэхэд уг хоёр авиа нэгэн авиалбарын хувилбар байхаа больсоныг толгой холбосон шүлэгийн баримтаар анхааран тэмдэглэжээ<sup>20</sup>.

**1-р хэсэгт холбогдох товч дүгнэлт:** Үсэгзүйн хүрээнд дээр дурадсан хэдэн баримтаас үзвэл, удаа дараа монгол бичигийн дотоодод, үсэгзүйн хүрээнд хийсэн “боловсруулалт”-ыг гадна талаас нь харвал тухайн өөрчлөлтийг санаачилан үйлэдсэн нутагийн аялгуутанд монгол бичигийг сурах, сургах, унших, бичихэд хялбар болгосон мэт санагдавч цаанаа нийт монгол туургатаны олон нутагийн аялгууг бичигээр нь нэгэдхэж ирсэн монгол бичигийн хувьд нэгэдхэх гол үүргий нь сааруулсаны дээр, олон аялгууны бие даан эрх тэгш хөгжих боломжийг нь хязгаарлахад хүрээд зогссонгүй, тухайн бүс нутаг буюу тухайн цаг үеийн нөлөө бүхий аялгууны онцлогийг бусад аялгуутанд хүчээр тулган хүлээлгэж уламаар хэлний оршин хөгжих гол үндэс болсон нутаг нутагийн аялгууны бие даасан онцлогийг аажимаар ойртуулах гэсэн зам руу санамсаргүй хөтлөжээ. Ойртон нягтрах нь үзэл бодол зэрэг зүйл дээр сайн байж болох боловч бүх юм, тухайлбал үндэстэн үндэстэний хэл аялгуу ний найгүй нэг болох нь их үндэстэн юм уу, зонхилох (төв халх) аялгуутаны хувьд таатай ч, ерөнхийд нь авч үзвэл бага үндэстэн юм уу, цөөнхи аялгуутаны хувьд яав ч сайн юмгүй, уусч үгүй болохын үүдийг санамсаргүй нээх шалтгаан болоход хүрнэ.

## 2. Зөв бичихзүй (ЗБЗ)-н хүрээнд:

**2. 1. “Утга салгах” тухай:** Монгол ахуй, монгол сэтгэлгээ нь монгол бичигтэй найрсаж ууссан байдаг бөгөөд энэ нь тухайн үгийн ЗБЗ-ээр илрэн гарч унших, бичих бүрт их бага аль нэгэн хэмжээгээр эх хэлнийхи нь унаган мэдрэмжийг сэлбэн сэргээж өгсөөр байжээ. Ямар нэгэн үгийн бичилгийг хэлшинжлэлийн үндэслэлгүй өөрчилөх, “засах” нь тэрхүү уугуул мэдрэмжид нь нөлөөлж, голдуу сайжруулан тэтгэх биш, муужруулан мохоож авиазүй, үг бүтэх ёсон, өгүүлбэрт үг холбон найруулах ёсон, зөв дуудахзүй гэх зэрэг хэлний төвшин болгонд өртөөлсөн олон алдааны эхийг тавьдаг байна.

<sup>20</sup> Ш. Чоймаа, “Монголын нууц товчоон”, Лувсанданзаны “Алтан товч” –эхийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2002, 35-р тал.



Харьцангуй түрүү үеэс утгад хэтэрхий шүтэж үгийн бичилгийг санааны дураар салаалан бичих явдал харагддаг ч ХХ зууны эхний гучаад жилд Шагж тэргүүтэй бичигийн нэгэн хэсэг хүмүүс “*утга өөр ахул дүрс өөр*” гэдэг зарчимаар монгол бичигийн уламжлалт бичилгийг их бага аль нэгэн хэмжээгээр өөрчлөн тухайн үед тулгар зохиосон толь бичигтээ тогтолцоо мэтээр тусгах болсон нь дараа дараагийн нэг бус толь болон одоо ч гэсэн Өвөр Монголд гарсан нэлээд толь бичигт уламжлагдсаар бөлгөө. Тэрхүү зарчимаар өөрчилөж зассан үгийг бичилгийг гаднаас нь үзэхэд жишээлбэл: монгол бичигийн *sigür-* [шүүр(эх)]- гэдэг үгийн бичилгийг салгаж “*шувуу савардан авах*”-ыг *sigür-* гэнэ, “*хүний урьтан булаах мэт*”-ийг *sigüre-* гэж бичнэ гэх мэтээр угтаа ганц бичилгэтэй олон үгийг салаалуулсан нь хүн, шувуу хоёрыг хармагц ялгахуйц мэт боловч өөр амьтан байвал яаж бичих вэ? уг үгийг шилжсэн угтаар хэрэглэх тохиолдолд алианаар нь бичих вэ? гэх зэрэг өдий төдий эргэлзээ эрхгүй гарах болно.

Хэлшинжлэлийн үүднээс, үгийн гарал үүсэл болон утгазүй, хэлзүйн төвшинд ийм өөрчлөлт засварыг цайруулах арга байхгүй. Наад зах нь тухайн үг өгүүлбэрт орлоо гэхэд шувуун дээр *шүүрч* гэж –ч-тэй, хүн дээр *шүүрэж* гэж –ж-тэй ялган бичих ёстой болно. Ингэж гэмээ нь зөв дуудахзүйн үүднээс угтаа нэг үгийг, ялгаж хоёр өөрөөр дуудахад хүрнэ гэсэн үг. Авиазүйн үүднээс тухайн үгийн эгшиг гийгүүлэгчийн байр хөндөгдөхөөс гадна угтаа дэвсгэр –г байх ёстой байтал нэг тохиолдолд нь дэвсгэр, нөгөөд нь угтаа байх ёсгүй –е эгшигээр амь авахад хүрнэ гэсэн үг.

Толь бичигт угтаа нэг байх ёстой үг утга салгасанаар бичилгэ салаалж хоёр өөр газар ороход хүрнэ. Энэ мэт өртөөлсөн олон ташаарал гарч улам тэлж газар авна гэсэн үг. Иймэрхүү маягаар “*утга салгасан*” үг цөөнгүй. Одоо монгол бичигт очир хонхыг *qongq-a* гэж, дотроо бөмөрцөгтэй бөөрөнхий хонх гэвэл *qongqu* гэж ялган бичих явдал багагүй үзэгдэнэ. Үгийн гарал, утгазүй, үгийн түүхэн бүтэцийн үүднээс авч үзвэл тийнхүү утга салгасан гэх олон үг цөм нэг хэлбэртэй байсан нь тодорхой харагдана. Академич Ринчен багшитаны номын санд буй Шагж авгайн толийг үзэхэд улаан, хүрэн, ногоон харандаагаар зассан зүйл бараг хуудас бүрт байдаг бөгөөд одоо бодоход гол зонхи нь “*утга салгасан*”-тай холбоотой байжээ. “*Утга салгана*” гэдэг нь бие даасан утгын хувьд байж болох ч нэгэн утгыг дотор нь хүнд хамаатай юу? шувуунд хамаатай юу? гэх мэтээр салбарлуулах нь хүн, шувуу хоёроор орчилон дуусдаггүй тул хэтэрхий өнгөц хандалга болох нь тодорхой бөлгөө. Тэгээд ч 2005 онд анх гарч, гурвантаа нэмэн засч хэвлэгдсэн профессор Ш. Чоймаа нарын “*Монгол хэлний хэлзүйн толь*”-д дээрхи мэт “*утга салгасан*” гэх өөрчилөлтийг хэлшинжлэлийн үндэстэй засаж ёсоор нь болгожээ<sup>1</sup>.

МонголбичигийнЗБЗ-нхүрэндэхидээрөгүүлсэнөөрчлөлтийнмөнчанарыгхэлшинжлэлийн үүднээс хэрхин тайлбарлаж болох, үүдэн гарах эцэсийн үр дүнгийн талаар үүнээс өмнө ч хөндөн ярьсан<sup>2</sup> тул дэмий олоньг нуршихаа үүгээр хязгаарлая.

<sup>1</sup> Ш. Чоймаа, М. Баярсайхан, Э. Мөнх-Учрал, С. Батхишиг, *Монгол хэлний хэлзүйн толь бичиг* (55.000 орчим үгтэй), I / II боть, - ВИБЛЮТНЕСА МОНГОЛИСА: Lexicon I –1 / Lexicon I –2, Улаанбаатар, 2005, [А-4: 794 тал / 713 тал], I боть, XI тал.

<sup>2</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол бичигийн үсэгзүй-зөв бичихзүйн асуудалд* (Бусад бичигтэй харьцуулан үзсэн нь), - Proceeding of the 4th Seoul International Altaistic Conference “Altaic Studies and Philology”, Seoul National University, Oct. 23-25. 2000, Seoul, pp. 171-177.

## 2. 2. “Хэлдэгээрээ бичих” гэдэгийн тухай:

2. 2. 1. Хэлдэгтээ ойртуулж бичнэ гэдэг нь өнгөц бодоход амар хялбарыг хүсдэг хүмүүний араншингаар сайхан зүйл мэт хүмүүст ухагдах боловч мөн чанартаа алс хэтэд ямар эрсдэл дагуулахыг боддоггүйтэй холбоотой. Худалдаа арилжаа, үйлэдвэрлэл гэх зэрэг ямар нэгэн ашиг хонжооны хүрээнд эрсдэл гэдэг зүйл дороо мэдэгддэг ахул хэлний эрсдэл гэдэг зүйл урт удаан хугацаанд үл илэрдэгээрээ ялгаатай. Гэвч хэлний аливаа нэгэн алдаа өртөөлөн улаалсаар, дэлэн тэлсээр яваандаа нэг мэдэхэд эргэж сэхэх аргагүйд хүрдэг, тэгээд ч мандан бадарч явсан өдий төдий хэл тухайн хэлтэнтэйгээ үгүй болсон олон жишээг бид мэднэ.

Монгол бичигээр уламжилан ирсэн олон бичвэрийг үзэхэд тухайн бичигчийн хэлний боловсрол мэдэлгэ хангалттай бус, нягтлан шалгахаас залхууран амарчилах зэрэг элдэв шалтгаанаар тухайн үг ямар байх ёстойг үл харгалзан, дуудалгадаа дөхүүлэн жишээ нь: *orasibai* > *orosibai* (энэ тохиолдолд *orusibai* биш), *jobalang* > *jobolang* (энэ тохиолдолд *jobulang* биш), *oytarqui* > *oytorqui* (энэ тохиолдолд *oyturyui* гэж галиглахгүй)<sup>23</sup> гэх мэтээр бичсэн байх нь харагддаг. Ийм баримт зөвхөн эр эгшигтэй үгэнд а > о болдог төдийгүй *göregesün* > *görögesün* (энэ тохиолдолд *görügesün* гэж галиглахгүй) гэх зэрэг эм эгшигтэй үгэнд буюу е > ө болсон тохиолдол буй. Ийнхүү өдий төдий үгийг хэлдэгтээ ойртуулан “харьцангуй” буруу бичих нь яв явсаар тухайн үгийн гарал, уугуул утга санаа нь зөвхөн тэр үгээр хязгаарлагдахгүй, түүнтэй язгуур, үндэс нэг бусад олон үгийн хүрээнд ч бүдгэрэн замхарч огт хамаагүй мэт болоход хүрдэг байна. Ямар учраас англичууд өнөөдөрийнхөө ярианы хэлнээс үлэмж зөрөөтэй болчихсон зөв бичихзүйгээ засахгүй, хэлдэгтээ ойртуулж бичихгүй байгаа юм бэ? гэдэгийн цаад учир нь тэр.

2. 2. 2. Тодорхой нэгэн бичигийн хүрээнд төдийгүй, түүнийг сольж орлосон бичигийн хүрээнд ч аливаа үгийн бичилгийг хэлшинжлэлийн үндэслэлгүй санааны зоргоор өөрчилөж засах нь тухайн үндэстэний эх хэлний унаган мэдрэмж, дархалааг нь бууруулахад хүрдэг талаар товч өгүүлэе. Төрийн тухайд өөрчилөж болдоггүй уламжлалт бодолго байх ёстой гэж хүн бүр мэддэг, ярьдагчилан үндэстэний хэл, бичигийн тухайд ч тийм бодолго байх ёстой гүн ухааны үндэслэл буй. Гэвч ..., Үүнийг өгүүлэхийн өмнө англи хэлний талаар нэг үеэ бодоход буюу 1990-ээд оноос хойш элдэв хаалтгүйгээр тодорхой ойлголттой болсон мэргэн уншигч та яагаад орчин цагийн англи хэлний дуудалга бичигээсээ зөрдөг юм бэ? толь бичиг үзэхэд толгой үг бүрийн ард дөрвөлжин хаалтанд дуудалгыг нь галиглан хаддаг юм бэ? тийм байталаа англи хэлний харьцангуй эртний байдалыг тусгасан ЗБЗ-тэй бичигээ манайхин шиг “хуучин, хоцрогдсон” гэж муушаахгүй байгаа юм бэ? ЗБЗ-гээ дуудалгадаа ойртуулж манайхин шиг яагаад засахгүй байгаа юм бэ? хэн бүхэний амнаас гардаг business гэдэг ганц үгээр жишээ авахад тэд нар яагаад “бизнес” гэж дууддагтаа ойртуулж ЗБЗ-гээ засахгүй байгаа юм бэ? гэдэгийг эргэцүүлэн нэг бодогтун. Англи хэлний дуудалга бичилгэ хоёр нь чухамдаа одоогийн монгол хэл, бидний хуучин гээд байгаа монгол бичигийн хэлний зөрөөгөөс хамаагүй их гэдэгийг та лав ажигласан байх гэж найдаж байна. Зөвхөн англи ч биш, франц, герман ... гээд бичсэнээрээ дууддаг хэл бичиг хаана ч байдаггүй. Гүн ухаан, хэлшинжлэл болон учир шалтгааны ухааны үүднээс, хэлдэгээрээ бичдэг хэл гэж байдаг уу гэдэгийг эргэцүүлэн үзэгтүн. “Хэл” гэж бид ярьдаг боловч “... хэл гэж энэ байна” гээд

<sup>23</sup> Igor de Rachewiltz, *Some Reflections on So-Called Written Mongolian*, - *Studia Tibetica et Mongolica*, (Festschrift Manfred Taube), Swisstal-Odendorf, 1999, pp. 235-246;

харуулах барим тавим зүйл байдаггүй, хийсвэр ойлголт бөгөөд хэл нь “хэлэхүй” буюу тухайн хэлний нутаг нутагийн аялгуугаар илэрдэг ажээ. Тэгэхээр ганцхан аялгуутай хэл гэж байдаггүй тул бичсэн ганц хэлбэр нь аль нэгэн аялгууны дуудалгад харьцангуй ойртож болох ч бусад аялгууны онцлогийг гаргах боломжгүй гэсэн үг. Энэ бол чухамдаа орон зайн ойлголт. Үүний дээр цаг хугацааны ойлголт зайлашгүй хамааралтай нь эргэлзээгүй. Үүнд: харьцангуй *одоо цаг* буюу өнгөрсөн ирээдүйг зааглах төдий “бодол”-ын *одоо цаг* байхаас туйлын *одоо цаг* гэж байдаггүй, “*одоо*” гээд хэлэхэд л тэр цаг чинь хэдийнээ өнгөрчихсөн байх тул гүн ухааны үүднээс бичсэнээрээ унших боломж ерөөсөө үгүй гэсэн үг. Үүнийг тэд нар мэддэг учираас мэддэггүй бидэн шиг зөв бичихзүйгээ засахгүй байгаа хэрэг. Бас засч гэмээ нь тухайн улс үндэстэний эх хэлнийхи нь унаган мэдрэмж доройтоно гэдэгийг давхар мэддэг байна. Жишээ нь: *business* гэдэг үгийнхээ бичилгийг дуудалгадаа ойртуулаад манайхин шиг *biznes* гээд ч юм уу засаад бичих юм бол тухайн үг “зав чөлөөгүй” гэсэн утга бүхий *busy* гэдэг үгээс үүссэн юм шүү гэж нууцхан хэлж, хэлний нь унаган мэдрэмжийг тэжээж, цэнэглэж өгөөд байдаг бичилгэ нь үгүй болж, яв явсаар олон нийтээрээ уг хоёр үгийн холбоог мартаж мэдэхгүй болно гэсэн үг. *Мартана* гэдэгийг “*тархи хамгаалах*” үйлдэл гэж зарим ухаанд үздэг ч ийм зүйл дээр тэр тайлбар огт хэрэггүй гэдэгийг тэд нар сайн мэддэг учир ЗБЗ-гээ засахгүй байгаа хэрэг. Өөр хэл бичигт ч ийм нарийн ширийн зүйл хадгалагдаж, түүнийг эзэд нь ойлгож, хамаагүй юмаар солилгүй хадгалан хамгаалсаар иржээ. Тухайлбал: Хятад бичигт “*ус*” (水) гэдэг ханз аль нэг үсэгийн бүтэцэд байж гэмээ нь ... тухайн зүйл хуурай юмтай огт хамаагүй, “*шингэн, нойтон, чийгтэй юм*” гэдэг утгыг илэрхийлж өгдөг байна.

Дээр өгүүлсэн эерэг нарийн ширийн зүйл монгол бичигт байсан эсэхийн талаар наад захын жишээгээр түр ч боловч эргэцүүлэн нэг бодоцгооё.

*Хөрөө, хутга, хялгас, шүд* ... гэх зэрэг олон үгийг бид одоогийнхоо бичилгээр хоор зуураа холбоотой гэх мэдрэмжийг олж харахгүй. Харин монгол бичигээр дээрхи хэдэн үгийг бичиж гэмээ нь *хирүгэ, хитуга, хилгасун, шидүн* ... гэх мэтээр цөм *хи-* буюу түүнтэй сэлгэдэг *ши-* хувилбар бүхий нэг язгууртай байгаа нь давын өмнө харагдаж, лавшируулан бодож үзвэл цөм “*тасла-, хэрчи-, огтло-*” гэсэн утгатай болох нь тодроод ирнэ. Энэ нь англи хэлний *business – busy* гэдэг хоёр үгийг холбон үздэгтэй зарчим адил. Одоо бидний *үлгэр* гэдэг үгийг монгол бичигт *үлигэр* гэж бичдэг байсан нь чухамдаа “*жиших, харьцуулах*” гэсэн утга бүхий *үли-* гэдэг үйл үгээс үүссэн нэр болохыг, *одоо нүүр* гэдэг үгийг монгол бичигт “*нигур*” гэж бичдэг нь эртний монгол хүний сэтгэхүйгээр “*нуудаг юм*” гэсэн санаа болохыг аяндаа мэдрэх жишээтэй. *Нүүр* гэдэг үгийн тэрхүү эртний утга нь монгол хүний сэтгэхүй, монгол хүний үйл хөдлөлд *одоо* ч гэсэн хэвээрээ байгаа нь хүүхэд айх ичихээрээ нүүрээ нуудаг, бас ичсэн тохиолдолд “*нүүрээ хийх газаргүй болох...*” гэдэг хэлэлгээс бэлээхэнээ харж болно. Монгол бичигтэй хүн монгол хэлний энэ мэт унаган мэдрэмжийг чөлөөтэй хүртэж, хэл сэтгэхүйн холбоогоо бэхжүүлсээр байдаг бол монгол бичиггүй хүнд тэр боломж хүртээлгүй гэсэн үг. Үүний дээр монгол бичигийн боловсрол нь монгол хүн монгол хэлтэй язгуур нэг япон. солонгос зэрэг Алтай овогийн хэлийг сурахад үлэмж дөхөм, улам ч сонирхолтой болохыг мэдрэх бөлгөө. Энэ нь тэдгээр хэлийг сурах төдийгүй харьцуулан судлахад ч чухаг баримт хэрэглэгдэхүүн болж өгнө. Жишээлбэл: япон хэлний “*тасла-, хэрчи-, огтло-...*” гэдэг утга бүхий *kiru-* гэдэг үгийн язгуур нь дээр жишээ авсан монгол хэлний *ki-* язгуур бүхий *хөрөө, хутга, шүд* ... зэрэг үгтэй ямар нэгэн холбоотой болох нь харагдана. Бас монгол бичигээр *sayara-* гэж бичдэг, одоогийн “*саара-, буура-*” гэсэн утга бүхий япон хэлний *sagaru, sagarime*

(харцаа доошлуул-) гэдэг үгийн хэлбэр нь орчин цагийн монгол хэлний “саара-” гэдэгтэй харьцуулахад монгол бичигийн хэлбэрт илүү ойр болохыг хялбархан харж болно. Солонгос хэлний “ус” гэсэн утга бүхий *mül* гэдэг үг нь “Монгол хуа-и и-юй” зэрэг монгол бичигийн дурасхалд *mölsün* гэж бичдэг, буриадын аялгуунд одоо ч *mölhün* гэдэг үгтэй утгын хувьд холбоотой байж болохыг гадаад дотоодын судлагчидын анзааран тэмдэглэсэн нь буй. Энэ мэт олон жишээг жагсааж болно.

Одоогийн бичилгийг харахад *дууриах – дуурайх, цуурайтах – цууриатах, сонины – сонингийн, Жамсраны – Жамсрангийн* гэх мэтээр нэг үгийг янз янзаар бичих дуудах болсон төдийгүй, нэг нь зөв байх ёстой ч, аль нь зөв болохыг ялгах аа хэдийнээ больжээ. Хэрэвзээ монгол бичигээр дээрхи үгийг яаж бичдэг билээ гэж бодох бөгөөс эхиний хоёр үгийг *дагурийаху, чагурайтаху* гэж бичдэг тул *дууриах, цуурайтах* гэдэг нь зөв юм байна гэж мэдэх болно. Бас нэгэн зүйл, монгол бичигээр *сонин, Жамсран* гэдэг үгийн эцэсийн –н гийгүүлэгч нь их инхэлиг биш, хойшоо сүүлтэй –н байгаа нь тодорхой харагдах тул *сонины, Жамсраны* гэх нь зөв юм байна шүү гээд дороо харагдах жишээтэй. Ингээд бодоход англи бичиг англи хүнд англи үгийн утга учирьг зөв ойлгуулдаг шиг, монгол бичиг маань монгол хүндээ эх хэлний мэдэлгэ, мэдрэмжийг нь ямагт дээшлүүлж, цэнэглэж өгсөөр ирсэн ажээ.

Одоо бид *давс, улс* гэж бичдэг бөгөөд гаднаас нь харахад бүтэц ойрхон юм шиг санагдахад хүрч хэрэвзээ хэн нэгэн шүлэгч сүүл холбох шаардалга гарвал уг хоёр үгийг шүлэгийн хоёр мөрт зэргэцүүлэн оруулахад ч бэлэн болжээ. Гэтэл *давс* гэдэг үгийн эцэсийн –с нь угтаа ардаа эгшигтэй буюу –су, *улс* гэдэг үгийнхи нь дэвсгэр –с буюу ардаа эгшиггүй тул тухайн хоёр үг, тухайн хоёр үгийн сүүлчийн дагавар нь хоёр өөр тул бүтэц ойролцоо гэж үзэх аргагүй болох нь. *Давс* гэдэг үгэнд байх ёстой –су нь *ус, цус, цас, цөс, нус, нулимс* гэх зэрэг олон үгэнд орж, “*нойтон, чийгтэй, хуурай бус*” гэсэн утга илэрхийлдэг дагавар байсан боловч одоогийн бичилгээс тэрхүү утгыг харах бололцоо хэдийнээ үгүй болжээ. Харин буриад аялгууны шүргэх –h- нь дээрхи –с-тэй дүйдэг тул буриад нөхөд *уһан* (ус), *шуһан* (цус), *саһан* (цас), *һүһэн* (цөс)... гэх мэтээр дандаа ардаа эгшигтэй бичдэг бол нөгөөхи *улс* гэдэг үгийг нь *улас* гэж дэвсгэр –с-ээр тэмдэглэн монгол хэлнийхээ зүйд нийцүүлэн зөв бичдэг байна.

Энэ мэт баримт жишээнээс үзвэл, англи хэл бичигт байдаг шиг дуудалга бичилгэ зөрүүтэй ч тухайн үгийн үүсэл гарал, хэлхээ холбоо, бүтэц тэргүүтэнийг нь тодруулан хүн бүрт эх хэлнийхи нь унаган мэдрэмжийг тэжээн тэтгэдэг онцлог, мөн хятад хэл бичигт байдаг шиг тодорхой сайн мэдэхгүй байлаа ч тухайн үгийн утгыг дүрсээр таамаглан тодруулах арга ... цөм монгол бичигт байсан боловч бусад хэл бичигт ерийн гэж үздэг энэ мэт эерэг онцлогийг монгол бичигийн тухайд дандаа “хоцрогдол” хэмээн муучилсаар ирсэн төдийгүй түүнд нь нэг бус монгол хүн өөрөө багагүй хүчин зүтгэсэнийг бид харамсалтай боловч мэдэх билээ.

### Ерөнхий дүгнэлт:

1. Монгол бичигийн ЗБЗ-н анх тогтсон зарчмыг үзэхэд хоёр гол зүйл эрхгүй анхаарал татдаг. Нэгд, монгол бичигийн ЗБЗ-г боловсруулагчид нь монгол хэлний хэвшинж (typology)-ийн онцлог төдийгүй нутаг нутагийн аялгууны ялгаа болон эгшиг гийгүүлэгч авиа сэлгэдэг байдалыг нарийвчилан судлаж түүнийгээ бичигт гайхалтай сайн тусхасан ажээ. Хоёрт, энэхүү гайхалтай тусхал нь монгол бичиг зохиох эхин үед анхнаасаа буй болсон уу?, эс бөгөөс одоогийн бидний боддог хэмжээгээр, монгол бичигийн хөгжилийн явцад аажим бүрэлдэн тогтсон уу?

гэдэг асуулт зүй ёсоор гарах бөгөөд аль аль нь, ялангуяа, хөгжилийн явцад боловсрон буй болсон гэж үзэх бөгөөс монгол бичигийн үүсэлийн асуудалд шууд хамааралтай, наад зах нь олон судлагчийн үздэгчилэн монгол хэлний хөгжилийн дунд үед буюу XIII зуунд яв ч биш, түүнээс бүр өмнөхи үед хамаарах учиртай болно. Үүнийг ч монгол бичигийн хэлний онцлог, тухайлбал: авиазүй, үсэгзүйн түүрүү үеийн дээрхи баримт хэрэглэгдэхүүн өөрөө нутлаж байна. Үүний дээр аливаа бичиг үсэгийн түүхийг авч үзэхэд тухайн бичиг нь тухайнхаа үеийн хэлнийхээ байдалыг харуулдагаас биш, өнгөрсөн байдалыг сөхөөн эргэж буюу ирээдүйн байдалыг зөгнөж тусгах явдал байдаггүй нэгэн чухал жишиг буйг бас мартаж аргагүй.

2. Монгол бичигийн ҮЗ болон ЗБЗ-н хүрээнд харьцангуй хожуу үед буй болсон элдэв засварыг гаднаас нь харахад цөм сурах, сургахад амар хялбар болгох гэсэн зорилго эрмэлзэл байсан боловч эцэсийн үр дүн нь нийт монгол туургатаныг хэл бичигээр нь нэгэдхэн зангидахын сацуу монгол хэлний нутаг нутагийн аялгууг бие даан хөгжих боломжийг давхар хангаж, хэлний хувьд нэгэн төв рүү тэмүүлэх хүчин болж ирсэн монгол бичигийн өвөрмиц онцлогийг санамсаргүй хөндөхөд хүрчээ. Товчоор хэлэхэд үсэгзүй болон зөв бичихзүйн хожимын элдэв “засвар” нь монгол хэлний нутаг нутагийн аялгуутаныг нэгэн төвөөс тусхаарлахад санамсаргүй хүргэсэн гэсэн үг. Юм бүхэн харьцангуй учир, бие даана гэдэг нь зарим үед нэн чухал зүйл мөн ч, нэгэн нэгэдмэл үндэстэний хэл бичигийн тухайд тийм ч хүсэмээр зүйл огт биш ажээ.

Монгол бичигийг аль нэгэн хэмжээгээр засч ирсэн оролдолго нь гаднаас нь харахад буюу үе үеийн “боловсронгуй болгогч”-ийн үгээр сурах, сургах, бичих, уншихад амар хялбар болж байна гэж итгэж байсан боловч амар хялбар юм болгон сайн байдаггүйн ёсоор нийт монгол туургатаныг хэл болоод бичигийн хувьд нэгэдхэж өгдөг байсан, нутаг нутагийн аялгууны өвөрмиц онцлогийг эрх тэгш хадгалан уламжлах боломжийг олгож өгсөн монгол бичигийнхээ тэр бүх чадамжийг их бага хэмжээгээр сааруулсаар, бууруулсаар иржээ. Чухамдаа “хэл” гэж бид ярьдаг боловч “энэ байна” гээд бариад авдаг бие бодтой зүйл байдаггүй, харин “хэлэх” гэдэг үйл явцаар илэрдэг. Тэрхүү “хэлэх” нь нутаг нутагийн аялгуутанд эрх тэгш хүртээлтэй ажээ. Харин тэдгээр нутаг нутагийн олон аялгуутаныг нэгэн хэлтэн болгон нэгэдхэх үүргийг хэлнийхээ хэв шинжид тохирсон бичиг нь гүйцэдхэж өгдөг байна. Хэрэвзээ үндэс(тэ)ний бичиг нь хэлнийхээ хэв шинжид тохирохгүй буюу аль нэгэн зонхилох аялгуутаны хэлний онцлогийг бусад аялгуутанд хүчээр тулган хүлээлгэх шинжтэй болж гэмээ нь мөнөөхи бичиг чухамдаа үндэстэнээ нэгэдхэх биш, харин ч нутаг нутагийн аялгуутаны (буюу ястаны) дотоод дургүйцэлийг бадарааж уламаар үндэстэн задрахын нэгэн үүдийг нээхэд хүрдэг нь хүмүүний араншин. Энэ талаар 1929 онд нэрт монголч эрдэмтэн академич Б. Я. Владимирцов

*“...Итак, монгольский языковой мир в настоящее время является в виде нескольких наречий, многох говоров, а общезго языка не существует вовсе.”<sup>24</sup>*

гэж хэлсэн байдаг бөгөөд бидэнд хэрэгтэй ч, монгол хэлний хувь заяаг шийдэж ирсэн гадаад дотоодын эрхэтэн дархатаны санаанд нийцээгүй юм болов уу. энэ тухай ярьсан бичсэннийг

<sup>24</sup> Б. Я. Владимирцов. *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, введение и фонетика*, Ленинград, 1929, стр. 19.

бид ер соносолгүй өнөөг хүрчээ. Бас 1928 онд академич Б. Я. Владимирцов Халимагт уншисан лекцэндээ дээрхи асуудалыг хөндөж монгол бичиг нь монгол туургатаныг хэлний нь хувьд нэгэдхэхийн сацуу нутаг нутагийн аялгууг өөр өөрийнхөө жамаар хөгжих боломжийг олгосоор иржээ хэмээн дүгнэсэн боловч уг лекц нь 1986 он хүртэл хаалттай байсан билээ<sup>25</sup>. Иймэд, аливаа хэлний нутаг нутагийн аялгуу байх нь бие биеийнхээ оршин тогтох, хөгжих нөхцөл болоод зогсохгүй “хэл” гэдэг ерөнхий ойлголтыг бүрдүүлдэг ажээ. Ингэж үзвэл бүх өвчинд уудаг ганц эм байдаггүйтэй адил “даяаршил” гэдэг зүйл техник технологид таарах боловч наад зах нь үндэстэн бүрийн хэл аялгуунд таарахгүй юм байх нь. Тэгэхээр “*Оршиё гэвэл ондоош! Устая гэвэл ижилс!*” гэдэг үг хэлэнд хамаатай болох нь! Ер нь бусадыг дууриана гэдэг өөрөөсөө холдохын нэр. Бид социализмын үед өөрөөсөө холдоод түүхээ хүртэл эрэхэд хүрсэн. Тэгээд германы нэрт монголч эрдэмтэн В. Хайссиг профессор “*Монголчууд түүхээ эрж байна*” гэдэг ном бичсэн нь герман, франц хэлээр гарч билээ. Харин бид одоо өөрсөдөө түүхээ хагас дутуу эрж эхлэсэн ч хэлээ эрэхэд хүрч магадгүй болжээ. Байдал иймэд хүрсэн тул энэ тухай хэлэхгүй байж гэвчихгүй нь.

Англи хэлтэй улс орон, хэлшинжлэлийн зарчимын хувьд монгол бичигтэй яг адил, магадгүй орчин цагийнхаа англи хэлтэй харьцуулахад манайхаас илүү зөрөөтэй (тэгээд ч толь бичигтээ толгой үг бүрийн ард дөрвөлжин хаалтанд дуудалгы нь хадаж өгдөг) ЗБЗ-гээ өнөөдөрийнхөө монгол хэлэнд ойртуулж шинэ үсэг авч “шийдсэн” бидэн шиг яагаад “засахгүй” байгаа юм бэ? гэвэл дэлхий нийтээр хүчээ авсан нэгэдмэл англи хэл үгүй болж, уламаар америкийн англи, британийн англи ... гэх зэрэг “олон англи” хэлэнд хуваахыг хүсээгүйд л байгаа юм, бас англи бичигийнхээ ЗБЗ-д найрсан шингэсэн эх хэлний унаган мэдрэмжээ гээхийг хүсээгүйд байгаа юм. Сурах, сургах, бичих, уншихад амар хялбар болгоно гээд яагаад манай Азийн хятад, солонгос, японууд латин үсэг авна гэж бидэн шиг дуулиан тарихгүй байгаа юм бэ? гэдэгийг бодож үзэгтүн. Харин бид бусадын үгээр ухаанаа залж, хэлний хувьд нэгэдмэл биш, олон монгол хэлтэн болохыг, тэр нь яваандаа нэгэдмэл монгол үндэстэнээ задлахыг хүсээд байгаа юм биш байгаа?!

3. XVIII зууны үеэс Монгол бичигийн дотоодод хийсэн олон “боловсруулалт”-ын анхны зорилго нь ялган уншихад хялбар болгоход чиглэсэн боловч чухамдаа монгол бичигийн нийт монгол туургатаны нутаг нутагийн аялгуутанд нийтлэг хүртээлтэй байсан онцлогийг нь сааруулахад санамсаргүй хүргэсэн боловч монгол бичиг хэл болон бичигийн хувьд нийт монголчуудыг нэгэдхэх үүргээ гүйцэдхэсээр XX зууны дөчөөд оныг хүргэсэн билээ. Гэвч энэ бүхэн нь аливаа зүйлийг амар хялбар болгохыг эрмэлздэг хүмүүний араншинд хэт шүтэн юмны мөн чанарыг мөчид ухаж гэмээ нь хэдий сайхан зорилго тавьсан ч эцэсийн үр дүн нь зорилготойгоо санамсаргүй зөрж бэлдогийг анхааруулан сануулж байгаа хэрэг.


Нэгэн зүйлийг нэмэн тэмдэглэхэд, дээрхи санаа оноо цөм түрүү түрүүчийн ном, өгүүлэлийн минь холбогдох хэсэг бөлөгт буй боловч оюутан судлагч нарын маань өнөөдөрийн байдал нэгэн дор цуглуулан өгүүлэхийг эрхгүй шаардах аястай болсон тул ийнхүү нэгэдхэн бичив. Түүнээс биш ...

<sup>25</sup> Г. И. Михайлов, *Из наследия академика Б. Я. Владимирцова*, - Mongolica, Москва, 1986, стр. 10-22; Б. Я. Владимирцов, *Монгол болон Ойрд овог аймагуудын утга зохиол ба хэлний эдүгээгийн байдал*, - Acta Mongolica, Volume 6 (267), Ulaanbaatar, 2006, 53-62-р тал.


4. Дээрхи олон баримтаас үзэхүл, монгол бичигийн зөв бичихзүйн анхны шийдэл нь бусад аль нэгэн бичигийн адил тухайн үеийнхээ зонхилох аль нэгэн аялгуутаны хэлний онцлогт тусхайлан тулгуурласангүй, нийт монгол хэлтэний нутаг нутагийн аялгууны онцлогийг зөв танин, цөмий нь эрх тэгш харгалзсан байх бөгөөд энэ нь зөвхөн монгол хэлний хөгжилийн түүхээр хязгаарлагдахгүй, гаралын хувьд монгол хэлний хамаарах Алтай овогийн бусад хэлний хөгжил хувисалыг судлахад чухаг баримт болж өгөх учиртай. Тухайлбал: монгол хэлний нутаг нутагийн аялгуунд сэлгэдэг бараг бүх эгшиг болоод гийгүүлэгч түрэгийн олон хэлнээ мөн адилхан сэлгэж, жишээ нь “*одор*” гэдэг үг *kön ~ kün, gün ~ kün* байгаа<sup>26</sup> нь Алтай овог хэлний нэгэдмэл онцлогийг харуулах нэгэн баримт гэж үзэж болох бөгөөд энэ талаар дээр цухас боловч толилуулсан гэж бодож байна.

<sup>26</sup> Kurtuluş Öztopçu. Zoumagaly Abuov – Nasir Kambarov, Youssef Azemoun. *Dictionary of the Turkic Languages* (English: Azerbaijani, Kazakhn Kyrgyz, Tatar, Turkish, Turkmen, Uighur, Uzbek), London & New York, 1996, [361 pp.], p. 40.c

Зураг № 1



Зураг № 1а




1. Ил хаан Өлзийтөөс Францын Гоо Филипп вантанд илгээсэн захидалаас (1305)  
[элэнцэг (< elinceg), өвөг (< ebuge), эцэг (< esige) гэдэг үгийг анхааргтун]

Зураг № 2



Зураг № 2а



2. Турфанаас олдсон монгол бичвэрийн нэг хуудас  
[эрт (< erte) гэдэг үгийг анхаарна уу]





3. Цогтын чулууны Их бичээс (1624)  
[*и*, *ү* -д цэг тавиагүйг эндээс харж болно]